



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2023/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Улаанбаатар хот
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Ц.Хатанболд, Б.Ариунаа, Д.Эрдэнэтуяа
Утас: 91925552, 99195208, 99569599

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.04.05 № 356
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 620,606.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 283,065.3 мянган төгрөгийн авлага, 120,426.4 мянган төгрөгийн бараа материал, 876,306.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 1,900,404.0 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 396,550.2 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 642,542.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 1,069,661.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 132,853.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 11,029.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 20,012.9 мянган төгрөгийг зарцуулан үлдэгдэл 8,996.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 4,397,239.2 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 4,385,108.5 мянган төгрөгөөр санхүүгийн тайланг зөрүүтэй нэгтгэсэн зөрчлийг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулж, 150.0 мянган төгрөгийн татварын орлогын гүйцэтгэлийн

282330478

зөрүүтэй илэрхийлсэн зөрчилд албан шаардлага, татварын орлогын гүйцэтгэлийг залруулахдаа холбогдож журам зааврыг баримтлаагүй 11,980.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага тус тус хүргүүлж шийдвэрлэв

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулах, Орон нутгийн ерөнхий орлогын дансанд татварын орлогын нэр төрлийг зөрүүлэн хааж, залруулга бичилт их хэмжээгээр хийж байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(Мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	906,698.00	571,230.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	321,646.10	309,661.10
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	240,062.20	177,861.40
34	УРЬДЧИЛГАА	1,860.00	1,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	341,129.70	81,907.50
36	НӨӨЦИЙН БАРАА	2,000.00	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,349,463.30	1,918,218.60
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
37100	Урт хугацаат хадгаламж	-	-
37200	Үнэт цаас	-	-
37300	Урт хугацаат зээл	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,349,463.30	1,918,218.60
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	3,194,739.30	1,844,646.60
39300	Биет бус хөрөнгө	154,724.00	73,572.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,256,161.30	2,489,448.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	31,006.80	13,048.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	31,006.80	13,048.50
41100	Богино хугацаат үнэт цаас	-	-
41200	Богино хугацаат зээлийн өглөг	-	-
41300	Өглөг	31,006.80	48.50
41400	Урьдчилж орсон орлого	-	13,000.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42100	Урт хугацаат үнэт цаас	-	-
42200	Урт хугацаат зээл	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,225,154.50	2,476,400.10
51	Засгийн газрын хувь оролцоо	4,225,154.50	2,476,400.10
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,758,554.00	455,561.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	-	-
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	-	-
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/	-	-
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	-	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-
51200	Хуримтлагдсан үр дүн	2,081,016.70	1,935,944.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	385,583.80	84,894.70
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
52	Хяналтын бус хувь оролцоо	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,256,161.30	2,489,448.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,260,108.10	1,024,097.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	545,696.10	620,606.10
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	420,179.00	283,065.30
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	294,233.00	120,426.40
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,981,582.30	876,306.20
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
37100	Урт хугацаат хадгаламж	-	-
37200	Үнэт цаас	-	-
37300	Урт хугацаат зээл	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,981,582.30	876,306.20
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	4,856,545.30	810,493.20
39300	Биет бус хөрөнгө	125,037.00	65,813.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,241,690.40	1,900,404.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,596.10	15,216.40
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,596.10	15,216.40
41100	Богино хугацаат үнэт цаас	-	-
41200	Богино хугацаат зээлийн өглөг	-	-
41300	Өглөг	1,596.10	13,243.50
41400	Урьдчилж орсон орлого	-	1,972.90
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42100	Урт хугацаат үнэт цаас	-	-
42200	Урт хугацаат зээл	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,240,094.30	1,885,187.60
51	Засгийн газрын хувь оролцоо	6,240,094.30	1,885,187.60
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,809,275.50	392,590.90
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	-	-
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	-	-
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/	-	-
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	-	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-
51200	Хуримтлагдсан үр дүн	4,115,749.00	1,392,454.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	315,069.80	100,142.20
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
52	Хяналтын бус хувь оролцоо	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,241,690.40	1,900,404.00

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (Мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,420,502.80	-	4,420,502.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,420,502.80	-	4,420,502.80
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	1,819,591.50	-	1,819,591.50
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,240,094.30	-	6,240,094.30
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,240,094.30	-	6,240,094.30
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(164,137.60)	-	(164,137.60)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,075,956.80	-	6,075,956.80
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(242.70)	-	(242.70)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	(4,190,526.40)	-	(4,190,526.40)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,885,187.60	-	1,885,187.60

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,794,392.40	1,235,761.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	412,375.80	645,618.20
110	Орлогын албан татвар	50,539.90	248,650.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	50,539.90	248,650.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	-	-
1103	ААН-ын орлогын албан татвар	-	-
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	-
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	-	-
113	Хөрөнгийн албан татвар	48,218.80	65,062.10
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	-	-
115	Онцгой албан татвар	-	-
116	Тусгай зориулалтын орлого	-	-
117	Гадаад үйл ажиллагааны орлого	-	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	313,617.10	331,906.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,996.90	7,807.80
1181	Газрын төлбөр	6,937.90	34,098.50
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	294,682.30	289,999.60
1183	Бусад татвар	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,142.40	116,816.70
120	Нийтлэг татварын бус орлого	127,142.40	116,816.70
121	Хөрөнгийн орлого	-	-
122	Тусламжийн орлого	-	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,254,874.20	473,326.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,329,956.40	888,013.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,329,956.40	888,013.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,198,567.40	832,254.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,375,256.90	306,052.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,173.00	37,618.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,308.80	261,201.10
2104	Хангамж, бараа материалын зардал	85,357.40	39,046.60
2105	Нормативт зардал	161,083.40	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,122.10	37,556.60
2107	Томилолт, зочны зардал	5,459.80	8,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,041.50	81,283.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,764.50	60,595.60
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,389.10	55,758.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	464,435.90	347,748.60
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	89,566.40	272,838.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,566.40	272,838.60
2200	Дотоод эх үүсвэрээр	89,566.40	272,838.60
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(89,566.40)	(272,838.60)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(20,100.00)	-
14	Бусад эх үүсвэр	-	-

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,100.00	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	354,769.50	74,910.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	190,926.60	545,696.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	545,696.10	620,606.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,269,802.7	1,048,904.4
УРСГАЛ ЗАРДАЛ	956,916.8	825,241.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	929,755.2	802,788.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	311,133.3	293,411.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,892.0	36,322.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	280,043.1	261,201.1
Хангамж, бараа материалын зардал	26,937.6	25,631.6
Нормативт зардал	615.3	-
Эд хогшил, урсгал засварын зардал	38,026.0	30,915.1
Томилолт, зочны зардал	9,342.2	8,900.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,976.2	114,900.6
Бараа үйлчилгээний бусад зардал	48,789.5	31,506.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,161.6	22,453.0
Бусад урсгал шилжүүлэг	27,161.6	22,453.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	227,562.5	223,662.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	82,323.4	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,269,802.7	1,018,872.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,101,203.0	1,002,554.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	168,599.7	16,317.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	129,070.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	99,038.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,012.90
21 УРСГАЛ ЗАРДАЛ	20,012.90
210 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,999.50
2104 Хангамж, бараа материалын зардал	3,907.50
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,003.10
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	14,089.00
213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13.30
2133 Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13.30
I ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,029.70
1311 Нэмэлт санхүүжилтийн орлого	11,029.70
III НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(8,983.20)
9 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,983.20

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа илрээгүй.

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 6 байгууллага, 1 төрийн сан, 1 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 3 тусгай сан нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад санал дүгнэлт гаргаж 8 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвд “Платиниум прогресс аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой 4,397,239.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

3.1 Төлбөрийн акт

Байхгүй.

3.2 Албан шаардлага

Татварын торгуулийн орлогын гүйцэтгэлийг 150.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Байхгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	4,385,108.41			1	4,385,108.41	1	4,385,108.41				
Дүн	1	4,385,108.41			1	4,385,108.41	1	4,385,108.41				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс			
									Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2	12,130.83			2	12,130.83						
Дүн	2	12,130.83			2	12,130.83						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	6	2	4		2			
2	ОНӨААН	1		1					
3	ЗГТС	3		3					
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	1	3	8		3			